

БАТЛАВ :
ЗАСАГ ДАРГА Б.МӨНХЗУЛ

“НААДМЫН ТАЛБАЙ ШИНЭЭР БАРИХ”
ажлын даалгавар

2024-07-25

Дугаар 05

Зүүнхөвөө

1	Зураг төсөв боловсруулах үндэслэл	Давст сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт
2	Захиалагч байгууллага	Давст сумын Засаг даргын тамгын газар
3	Байршил чиглэл	Увс аймгийн Давст сумын 2-р баг
4	Хөрөнгийн эх үүсвэр	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 98,000,000 төгрөг
5	Зориулалт	Наадмын талбай шинээр барих
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
6	Үндсэн байгууламж	<ol style="list-style-type: none">1. Нийт газрын хэмжээ 1га талбай2. 0,6 га талбайг тойруулж 1,6 м өндөртэй, бетон суурьтай гоёлын төмөр хашаа барих3. Хүндэтгэлийн нэг том асар барих /15 м урттай, 6 м өргөнтэй, 3,5 м өндөртэй, мэдээлэл тогтоож байрлуулах зориулалт бүхий 0,6 м өргөн хөмсөгтэй, дотроо ширээ сандалтай байх /4. Үзэгчдийн 3 эгнээ сандал 2 талаар барих /66 м урттай, 2,6 м өргөнтэй, 6 см-ийн квадрат төмөр рамтай байх бөгөөд 4 м урт, 2,6 м өргөнтэй 12 ширхэг ус нэвтэрдэггүй сайн чанарын материалаар хийсэн салгаж авах боломжтой сүүдрэвчтэй, сандал террасан шалны материалтай байх/5. Үзэгчдийн сандалнаас дотогш 1 метрийн зайд тойруулж 2 м өргөнтэй цементэн зам тавих6. Асарын 2 талд /баруун талд 2, зүүн талд 2/ 2х3 харьцаатай, 4 см квадрат төмрөөр хийсэн аннос тогтоох зориулалттай 4 ширхэг бэхэлгээ бүхий хүрээ байрлуулах7. Талбайн нэг хэсэгт урлагын тоглолт хийх зориулалттай 6 м урттай, 4 м өргөнтэй тайз тохижуулах8. Талбайн хоймор хэсэгт төрийн далбаа байрлуулах 1 ш тугны том суурь, байгууллагуудын туг байрлуулах зориулалт бүхий 5 ш тугны суурь нийт 6 тугны суурь хийх9. Бөхийн гарын даа байрлах болон бөхчүүд хувцасаа солих 2х3 харьцаатай 2 ширхэг сайн чанарын материалтай асартай байх10. 1 га газрын таарыг хусаж тэгшлэх